



# ИРГЭНИЙ ЗОРИГ НАМ

## ИРГЭНИЙ ЗОРИГ НАМЫН УЛС ТӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

03.27

Дугаар 17

Улаанбаатар хот


Ерөнхийлөгчийн сонгуулийн  
мөрийн хөтөлбөрийг батлах тухай.

Улс төрийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Иргэний Зориг Намын дэвшүүлэн  
ахлах Мөрийн Хөтөлбөрийг хавсралтын ёсоор баталсугай.

ХУРЛЫГ ДАРГАЛСАН



 Г.АЛТАН – ОЧ / ДЭД ТЭРГҮҮН /

## ЭХ ОРОН - ЭВ НЭГДЭЛ

Монголчууд бид улс орон, нийгмийн хөгжлийн шинэ үзэл, баримтлал, хэв загварыг эргэлт буцалтгүй сонгосноос хойш арван жил өнгөрч байна. Энэ хугацаанд ардчилсан нийгмийн үндэс суурь болох хүний сонголтын эрх чөлөө, хувийн өмчийг баталгаажуулах талаар багагүй ахиц амжилт олсон боловч эдийн засаг, нийгмийн сөрөг үр дагавар нэмэгдэж, төрийн бодлогын алдаа дутагдалын улмаас нийгмийн хөгжил урагшлахаасаа илүү ухарч саатах бодит аюул нүүрлэж байна.

Иймд Монгол улсын Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд эх орныхоо хувь заяа, цаашдын ирээдүйн талаар хариуцлага хүлээх үүрэгтэй хэмээн үзэж хүний эрх, эрх чөлөө, ардчилал болон хүмүүнлэгийн зарчмын үндсэн дээр эдийн засаг, улс төр болон оюуны хөгжлийн хувьд эх орноо сэргээн мандуулах зорилго бүхий хөтөлбөрөө түмэн олондоо толилуулж байна.

Монгол оронд **хүмүүнлэг амьдрал, чадварлаг төр, хүчирхэг эдийн засаг, эвсэг харилцааг** хөгжүүлэхийн төлөө өөрийн мөрийн хөтөлбөрөө тууштай хэрэгжүүлж, ардчилал, эрх ашгийн эрэмбэлэл, андын зөвшилцөлийн зарчмыг ямагт эрхэмлэн мөрдөх болно.

### Хөтөлбөрийн зорилго

- Монгол хүнээ хөгжүүлж, хүний эрх, эрх чөлөө, өмч хөрөнгийн халдашгүй байдлыг чандлан сахиж, шудрага ёсыг нийгмийн амьдралын өрдийн хэм хэмжээ болгоно.
- Төрийн чадварлаг үйл ажиллагаа, эдийн засгийн давшингуй хөгжил, эрхзүйт нийгмийн тогтвортой хөгжлийг ханган бэхжүүлж, ардчиллын ололт амжилтыг бататган хэвшүүлнэ.
- Орон нутгийн засаг захиргааны нэгжийг томсгон, засаглалын чадварыг сайжруулж, өөрөө удирдах ёсыг бэхжүүлнэ.
- Нүүдлийн соёл-иргэншилийн үнэ цэнэт зүйлсийг залгамжлан хөгжүүлж, орчин үеийн техник, технологийн ололтыг уламжлалт соёлын баялаг уламжлалтай бүтээлчээр хослуулж хөгжүүлнэ.
- Тусгаар тогтнолоо сахин хамгаалж, талуудын эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан хүндэтгэлт, эв найрт, хүмүүнлэг олон улсын харилцааг хөгжүүлнэ.

- 76
- Үндэсний эрх ашгаа дээдэлж, Монгол түмний оюуны өв, үе үеийнхний ололт амжилт болсон нийт үндэстний өмч-нийгмийн баялагийг зохистойгоор арвижуулан хөгжүүлнэ.
  - Хүний амьдралын эх булаг болсон байгалийг нандигнан хайрлаж, байгаль-хүн-нийгмийн зохист харилцааг тогтоож, ухаалаг хэрэглээг бий болгоно.
  - Хүн төрөлхтний ололтоос цуцалтгүй эзэмшихийн сацуу үндэсний амжилтаа бататган хөгжүүлж, дэлхийчлэлд эзлэх байр сууриа үндэслэлтэйгээр тодорхойлно.

### Эрхэмлэх зарчим

- Төр, засаг нь нийгмийнхээ өмнө хариуцлага хүлээдэг тогтолцоог хэвшүүлэх.
- Нийгмийн хөгжлийн уламжлал, шинэчлэлийг зохистой хослуулж, бүтээлч ололтыг дэвшилттэйгээр залгамжлан хөгжүүлэх.
- Нийгмийн эрх ашгийг хэсэг бүлгийн болон хувийн эрх ашгаас дээгүүр тавих.
- Зөвшилцөл, ойлголцол, андын ухааралт арга барилыг аливаа асуудал шийдэх эрхэм зорилго болгох.
- Ямарваа ололт, шинэ санаа, дэвшилтэт бүхнийг хэн үүдэв хэмээн өөнтөглөн үзэлгүй өөриймсөгөөр хүлээн авч, тухайн нөхцөлд нийцүүлэн хэрэглэх.
- Оюун санааны эрх чөлөө, олон ургальч үзлийг хөгжүүлж, цөөнхийн санал бодолд ямагт бодитой хандах.

### 1. ХҮМҮҮНЛЭГ АМЬДРАЛ

**Эрхзүйт нийгмийг тогтоон, эрхэмлэл хүндэтгэлийн уламжлалаа сэргээн, тус суртахуунт, соёлч, бүтээлч, нөхөрсөг амьдрал, хүнлэг, нигүүлсэнгүй харилцааг бий болгож, монгол хүнээ өв тэгш хөгжүүлэх нь уг хөтөлбөрийн үндсэн зорилгын нэг мөн.**

Нийгмийн хөгжлийн гол хүчин зүйл нь өндөр мэдлэг, боловсрол бүхий, эрүүл саруул, мэргэжлийн ур чадвар бүхий иргэн хүн хэмээн үзэж буй тул иргэддээ боловсрол олж авах бүхий л бололцоог нээж, өөрийгөө хөгжүүлэхийн төлөө хариуцлага хүлээн, иргэд өөрийнхөө чадварыг хөгжүүлж, мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, ялангуяа онцгой авъяас, ялгарах чадварыг хөгжүүлэн дэмжихийг онцгой анхаарна.

Нийгмийн халамжийн тогтолцоог шинэчлэн хөгжүүлж, юуны өмнө хөгшид, нялхсыг Төрийн ивээлд авч, асрамж халамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг дэмжинэ.

Хүний амьдрах орчныг эрүүл саруул байлгаж, амьдралын амгалан тайван байдлыг хангана.

Хүний өмнө адил тэгш байх зарчим, шудрага ёс, ёс суртахуунт харилцааг төрийн амьдралын ердийн хэм хэмжээ болгоно.

### 1. ЧАДВАРЛАГ ТӨР

#### Хүний эрх

**Хүний эрх бол хувь хүний эрх бөгөөд бусдын халдашгүй эрхтэй тэнцлээгүй нөхцөлд юугаар ч хязгаарлаж болшгүй зүйл юм. Иймээс төрийн үндсэн үүргийн нэг бол хувь хүний эрх болон түүний аюулгүй байдлыг дархлан хамгаалахад оршино.**

Хүний эрхийг зөвхөн тунхаглах биш хамгаалах найдвартай эрх зүйн орчин болон төрийн засгийн үндэс, нөхцлийг бий болгохын төлөө тууштай тэмцэнэ.

Хүний эрхийг хамгаалах эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгоход онцгой ач холбогдол өгч түүнийг төрийн бодлогын нэн чухал хэсэг хэмээн үзнэ. Юуны өмнө төрийн ардынхаа амьжиргааны төвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн эдийн засгийн цогц бодлого хэрэгжүүлж түүний үрээр иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ. Амьдралынх нь эдийн засгийн үндэс хангагдсан нөхцөлд хүний үндсэн эрх найдвартай хамгаалагдаж иргэн хүн өөрийн сонголтоо чөлөөтэй хийх, эрхээ бүрэн гэрээлэх бололцоо нээгдэх болно.

Хүний эрх нь засаглалын хэлбэрээс үл хамааран хамгаалагдсан байх зарчмыг баримтална. Төр, засгийн үйл ажиллагаанаас болон засаг захиргааны байгууллага, албан тушаалтны дур зоргоос шалтгаалан хүний эрх зөрчигдөх явдлыг арилгах талаар тууштай тэмцэхийн сацуу төрийн болон засаг захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, албан тушаалтны хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх эрх зүйн үндсийг бий болгоно.

Иргэдийн амгалан тайван амьдрах, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших бүхий л нөхцөлийг хангахад чиглэсэн хуулийн хүрээнд хөнгөн шуурхай үйлчлэх төрийн тогтолцоог төлөвшүүлэн хэвшүүлэх замаар иргэн хүний халдашгүй байдлыг баталгаажуулах явдалд онцгой анаахрна.

#### Төр засаглал

**Улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан зорилтуудыг цаг тухайд нь ажил хэрэгчээр шийдвэрлэх, шинэчлэлийн үйл явцыг эрчимтэй хэрэгжүүлж, эдийн засгаа хямралаас гаргах нөхцлийг бүрдүүлж, улстөрийн хямралаас үл шалтгаалах төрийн тогтолцоо бий болгохыг төр зорилго болгоно. Төр нь иргэн хүний эрхийг хамгаас дээдэлдэг, үйл ажиллагаа нь ямагт хуульд захирагдан, хуулийн дагуу явагддаг байх ёстой гэж үзэж байна.**

48

Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тухайн үеийн нөхцөл шаардлагад нийцсэн ардчилсан төрийн тогтолцоо тогтоохыг зорино. Чингэхдээ УИХ, Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж ажиллах бөгөөд улс орны тухайн үеийн эдийн засгийн хүчин чадал, хөгжлийн бодит байдалтай нийцсэн нийгэм эдийн засгийн хөгжилд дарамт учруулахааргүй цомхон байх бөгөөд төрийн үйл ажиллагааны үндсэн хэмжүүр нь түүний бүтээлч чадвар гэж үзнэ.

Төрийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах, нийгмийн хяналтыг сайжруулах замаар хариуцлагыг өндөржүүлж, төрийн үйл ажиллагааг бүхэлд нь нанаржуулах нь эрхэм зорилт мөн.

Төр засаглалын тогтолцоог хууль цаазын ноёрхол, дэг журам болон сахилга баттай холбон ойлгох учиртай. Иймд төр засгийн үйл ажиллагаанд хуулийн ноёрхол тогтоож эрхзүйт нийгмийн харилцааг хөгжүүлэх, бүх шатны засаглалын хомсдолыг арилгаж түүний үүрэг, оролцоог бүх талаар сэргээн эрчимжүүлэх зорилт тавьж ажиллана.

Үндсэн хуулиар олгогдсон эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн сацуу хээл хахууль, өр нь аливаа хуйвалдаан, сөрөг үзэгдлээс ангид байх жишгийг үлгэрчлэн тогтооно. Төр засаглалын хомсдолыг арилгаж төрийн үйл ажиллагаанд хуулийн ноёрхол, сахилга бат дэг журмыг тогтоож чадсан нөхцөлд төр нь чадварлаг болох төдийгүй Монголын нийгэмд газар авч буй гэмт хэрэг, хээл хахууль, ядуурал, боловсролын доройтол, оюуны хомсдол, архидалт зэрэг сөрөг үзэгдлүүдийг арилгаж, нийгэм хямралаас гарч чадах болно.

### 1. ХҮЧИРХЭГ ЭДИЙН ЗАСАГ

**Хүчирхэг эдийн засаг гэдэг бол эдийн засгийн бүхий л нөөц бололцоогоо оновчтойгоор дайчлан, бүтээхүй хүчний зөв зохистой зохион байгуулж, улс орны эдийн засгийн тогтвортой байдлыг ханган, нийгмийн хөгжлийн үндэс суурийг баттай тогтоохыг хэлнэ.**

#### Эдийн засгийн бодлогын зарчим

Иргэдийн чинээлэг амьдралыг хангахад чиглэгдсэн тогтвортой өсөлт бүхий эдийн засгийн оновчтой тогтолцоог бүрдүүлж, эрчимтэй хөгжүүлэхийг зорино. Эдийн засгийн зөв бодлогын үр дүн, шалгуур нь иргэдийн амьжиргааны төвшин мөн.

Эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл нь материаллаг эх үүсвэр төдийгүй иргэдийн мэдлэг боловсрол, мэргэжлийн өндөр ур чадвар, эрүүл мэнд, бүтээлч уур амьсгал гэж ойлгоно.

#### Татвар, төсвийн бодлого

Татвар, төсвийн бодлогын үндсэн зорилго нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, улмаар үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдүүлэх, төсвийн тэнцвэрт байдлыг тогтооход чиглэгдэнэ.

Татварын системийг шинэчлэж, шинэ нөхцөлд зохицсон татварын тогтолцоог бий болгоход онцгой анхаарна. Татварыг энгийн, хялбар болгох, төрлийг цөөрүүлж, хэмжээг багасгах замаар татварын ачааллыг бууруулахын зэрэгцээ, татварын үүргийг төсөв бүрдүүлэх асуудалтай уялдуулан шинэчлэх биш, харин эдийн засгийн өсөлт бий болгох талаар анхаарч ажилна.

**Үндэсний үйлдвэрлэл**

Үндэсний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, үйлдвэрлэгчдийн эрх ашиг хамгаалах, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэхэд чиглэгдсэн бодлогыг дэмжинэ.

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулах, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж хувийн бизнесийн үйл ажиллагаанд саад учруулах, хүнд суртал гаргах зэргийг үндсээр нь арилгах, энэ хүрээнд үр өгөөжтэй, тогтвортой байлгахад чиглэгдсэн бодлого баримтална.

Шилтэт төхник, технологи нэвтрүүлэх, улс орны хэмжээнд стратегийн ач холбогдол бүхий салбарт үйлдвэрлэл эрхлэн явуулах, эдийн засгийн өсөлтөд хөрвитой нөлөө үзүүлж чадахуйц үйлдвэрлэл эрхлэн явуулж буй үндэсний үйлдвэрлэгчдийг татварын хөнгөлөлт үзүүлэх, тодорхой хугацаанд чөлөөлөх, зөвшөөрлийн хөнгөлөлттэй зээл олгох, төсвийн хөрөнгө оруулалт хийх зэргээр эрхлэн дэмжих бодлого баримтлах учиртай.

**Ажилгүйдэл ба ядуурал**

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах асуудлыг макро эдийн засгийн бодлоготой хамт зохиож үзэхийн зэрэгцээ үр ашигтай ажиллаж чадахуйц хөдөлмөрийн зах зээлийг бий болгохыг зоринo.

Хөдөлмөр эрхлэх зорилгоор нүүн шилжих, хөдөлмөр эрхлэх газраа чөлөөтэй сонгох бололцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох эрх зүйн орчинг бий болгоно.

Хөдөлмөрийн зах зээлийг цаашид бэхжүүлэн хөгжүүлнэ. Ажилгүй хүмүүст давхар ажил олгох сургалтыг хөдөлмөрийн биржийн дэргэд зохион явуулах, хувиараа хөдөлмөр эрхлэх, жижиг дунд үйлдвэр байгуулах явдлыг тууштай дэмжинэ.

**ЭВСЭГ ХАРИЛЦАА**

*Хүмүүн хоорондын хийгээд улс хоорондын харилцаа, тэрчлэн байгаль орхитой харилцах харилцаа нь андын ёс, найрсаг, харилцан үйлчилгээ, эвлэрэл, эв нэгдэлд тулгуурлах учиртай бөгөөд энэ нь үндэсний үйлдвэрлэл, байгалийн оршин тогтнохуйн язгуур үндэс гэж үзнэ.*

Төрийн үйл ажиллагаа нь олон намын тогтолцоо, олон ургальч үзэлд тулгуурлан, улс эх орны эрх ашгийг юуны өмнө дээдэлдэг, засаглалын үүрэг, үйл ажиллагааны үндэс болж, хариуцлагын хяналтыг харилцан тогтоохыг дэмжинэ.

50

төрийн хүчнүүд нь сөрөг хийгээд шүүмжлэлт байр суурийг зөв хослуулж, шүтэлцэж, туйлшрах биш зөвшилцөл, ойголцол, найрсаг харилцааг үйлчилгээгээ хийж, ажиллагаандаа мөрдлөг болгохыг чухалчлах ёстой гэж үзнэ.

орныхоо тусгаар тогтнолыг хангаж, улс хооронд тэгш эрхтэй, харилцан ашигтай, бие биенийг хүндлэн андалсан хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчмыг баримттай баримтална.

нийгэм, байгалийн зохист харилцаа, харилцан шүтэлцээг бий болгож байгалийн унаган төрхийг хадгалах, экологи нөхцлийг хамгаалахын зэрэгцээ байгалийн баялаг, эх үүсвэрийг зохистой, ухаалгаар ашиглах нь хамгаалалтын гол арга гэж үзнэ.

байгалийн нөөц баялагийг аль болох иж бүрэн, хаягдалгүй технологиор ашиглах бодлогыг баримталж, хүрээлэн буй орчны эвдрэл сүйрлийг нөхөн сэргээж, нөөц баялагийг зохистой ашиглах хууль эрхзүйн тогтолцоог нягтлан сайжруулж, орчны хэрэгжилтийг чангатгах талаар бодлого явуулна.

орчны засгийн хөгжлийн бодлогыг байгаль орчин, экологийн бодлоготой нийцүүлэхийн зэрэгцээ байгаль орчны бохирдолтын хохиролыг нийгэм бус харин хохирол учруулж байгаа этгээд хариуцаж байх зарчим бүхий бодлогыг баримтлана.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ИРГЭНИЙ ЗОРИГ НАМААС НЭР  
ДЭВШИГЧ ГӨРӨӨЧИН ОВГИЙН ЛУВСАНДАМБЫН ДАШНЯМ**